# ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛЬ, ТОГТООЛЫН ТӨСЛҮҮДИЙГ ЭЦСИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН ТАЛААРХ ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТАНИЛЦУУЛГА

2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр | Улаанбаатар хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нарын 4 гишүүнээс 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороонд шилжүүлсэн.

Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёололтой холбогдуулан асуулт асууж, хариулт авлаа.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар төрийн албан хаагчийн сахих ёс зүйн хэм хэмжээг тогтоох зайлшгүй шаардлага тулгарч байгаа өнөөгийн цаг үед хууль батлагдсанаар бүх шатанд хүнд суртал, зөрчил, шударга бус явдлыг таслан зогсоох, нийт төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэхэд онцгой анхаарч, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар санал хэллээ.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг Байнгын хорооны хуралдаанаар явуулахад Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасныг баримтлан, зарчмын зөрүүтэй 6 санал, найруулгын 1 саналын томьёоллоор санал хураалт явуулж хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дэмжлээ.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхийн дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган, төслийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, Байнгын хорооны танилцуулга болон зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт

бэлтгэсэн талаарх Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА** **Б.БАТТӨМӨР**

**Нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт:**
**2023.05.03**

## ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ

**1.**Төслийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9.2 дахь хэсэг нэмэх:

“9.2.Улсын Их Хурал төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг баталж, мөрдүүлнэ.”

**Санал гаргасан: Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо**

**2.**Төслийн 11 дүгээр зүйлийн 11.6.1 дэх заалтын “бодлого” гэсний дараа “, үндэсний хөтөлбөр” гэж нэмэх.

**Санал гаргасан: Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо**

**3.**Төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “Засгийн газар нь” гэснийг “Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь” гэж, “Ёс зүйн дэд хорооны” гэснийг “энэ хуулийн 13.3-т заасан” гэж өөрчлөх.

**Санал гаргасан: Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо**

**4.**Төслийн 16 дугаар зүйлийн 16.1.4 дэх заалтын “төрийн албанаас” гэсний өмнө “Төрийн албаны тухай хуульд заасны дагуу” гэж нэмэх.

**Санал гаргасан: Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо**

**5.**Төслийн 20 дугаар зүйлийг хасах.

**Санал гаргасан: Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо**

**Найруулгын санал:**

**1.**Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын “ажил хэргийн санаа бодлыг үл хүндэтгэх” гэснийг “ажил хэрэгч саналыг үл хайхрах” гэж, 8.1.5 дахь заалтын “хясан боогдуулахгүй” гэснийг “хязгаарлахгүй” гэж, 8.2.3 дахь заалтын мэдээллийг бусдад дамжуулах,” гэснийг “мэдээллээр бусдыг” гэж, төслийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалтын “Дэд хорооны” гэснийг “энэ хуулийн 15.1.5-д заасан” гэж, 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтын “тухайн албан хаагчийг дуудан ирүүлж,” гэснийг “тухайн албан хаагчаас биечлэн” гэж тус тус өөрчлөх, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “10.1.” гэсний дараа “, 10.2” гэж нэмэх, төслийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийн “Энэ хуулийн 8.1, 8.2-т заасан” гэснийг хасах.

**Санал гаргасан: Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо**

**Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо**

# ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ

**Нэг.Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар**

**1.**Төслийн 2 дугаар зүйлийн "37 дугаар зүйлийн 37.1.7," гэснийг хасах.

**Санал гаргасан: Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо**

**Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо**

Нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт:

Төсөл

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

# ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ТУХАЙ

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилго

1.1.Төрийн албан хаагч ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэх эрхэм зорилгоо ухамсарлаж, төрийн ажил үүргийг гүйцэтгэхдээ хуулиар тогтоосон ёс зүйн хэм хэмжээг чандлан биелүүлэх үнэт зүйлс, соёлыг төлөвшүүлж, төрөө дээдлэх ард түмний итгэлийг бэхжүүлэхэд энэ хуулийн зорилго оршино.

### 2 дугаар зүйл.Хуулийн зорилт

~~2.1.Энэ хуулийн зорилт нь төрийн албан хаагчийн ёс зүйн үнэт зүйлс, нийтлэг хэм хэмжээ, шаардлагыг тодорхойлж, түүнийг хангуулах үйл ажиллагааны зохион байгуулалт, журмыг тогтоож, төрийн албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэхтэй холбогдсон нийтлэг харилцааг зохицуулахад оршино.~~

**2.1.Энэ хуулийн зорилт нь төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим, нийтлэг хэм хэмжээг тогтоох, сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх, олон нийтэд мэдээлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.**

### 3 дугаар зүйл.Төрийн албан хаагчийн ёс зүйн ~~тухай~~ хууль тогтоомж

3.1.Төрийн албаны хаагчийн ёс зүйн ~~тухай~~ хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль[1], Төрийн албаны тухай хууль[2], **Эрүүгийн хууль**[3], **Авлигын эсрэг хууль**[4], Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг

[1] Монгол Улсын Үндсэн хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.
[2] Төрийн албаны тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2018 оны 1 дугаарт нийтлэгдсэн.
[3] Эрүүгийн хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2016 оны 07 дугаарт нийтлэгдсэн.
[4] Авлигын эсрэг хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2006 оны 35 дугаарт нийтлэгдсэн.

сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль[5], **Захиргааны ерөнхий хууль**[6], **Хөдөлмөрийн тухай хууль**[7], энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

**4 дүгээр зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ**

4.1.Энэ хуулийн үйлчлэлд Төрийн албаны тухай хуульд заасан төрийн улс төрийн, төрийн захиргааны, төрийн тусгай, төрийн үйлчилгээний /цаашид “төрийн албан хаагч” гэх/ албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагч хамаарна.

~~4.2.Төрийн албаны чиг үүргийн онцлогийг харгалзсан зарим тусгай зохицуулалтыг энэ хуульд нийцүүлэн холбогдох хууль тогтоомжоор тогтоож болно.~~

~~4.3.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд заасны дагуу төрийн тодорхой чиг үүргийг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтанд тавигдах ёс зүйн хэм хэмжээ, гомдол гаргах, хянан шийдвэрлэх асуудлыг гэрээнд тусган зохицуулна.~~

**4.42.Авлигын эсрэг хуулийн 4.1.3, 4.1.4, 4.1.5, 4.1.7, 4.1.9-д заасан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарна.**

**5 дугаар зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт**

~~5.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:~~

~~5.1.1.“төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ” гэж энэ хуульд болон түүнд нийцүүлэн эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас тогтоосон төрийн албан хаагчийн албаны чиг үүргээ гүйцэтгэхдээ хувь хүний хандлага, зан харилцааны хувьд дагаж мөрдөхөөр тогтоосон хэм хэмжээг;~~

~~5.1.2.“төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил” гэж төрийн албан хаагч нь энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасан ёс зүйн нийтлэг, тусгай хэм хэмжээ, шаардлагыг зөрчсөн үйлдэл, эс үйлдлийг;~~

~~5.1.3.“төрийн албан хаагчийн ёс зүйн хариуцлага” гэж төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд хүлээлгэх хариуцлагын арга хэмжээг.~~

---

[5] Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 8 дугаарт нийтлэгдсэн.
[6] Захиргааны ерөнхий хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2015 оны 28 дугаарт нийтлэгдсэн.
[7] Хөдөлмөрийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2021 оны 31 дугаарт нийтлэгдсэн.

5.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

5.1.1.“төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээ” гэж төрийн албан хаагчийн хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд баримтлах ёс суртахууны нийтлэг шаардлагыг;

5.1.2.“төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил” гэж энэ хуульд заасан ёс зүйн нийтлэг шаардлагыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг;

5.1.3.“төрийн албан хаагчийн ёс зүйн хариуцлага” гэж энэ хуульд заасан ёс зүйн зөрчилд хүлээлгэх арга хэмжээг.

~~ХОЁРДУГААР БҮЛЭГ~~
~~ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЭРХЭМЛЭХ ҮНЭТ ЗҮЙЛС,~~
~~ЁС ЗҮЙН НИЙТЛЭГ ХЭМ ХЭМЖЭЭ, ШААРДЛАГА~~

## ХОЁРДУГААР БҮЛЭГ
## ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЗАРЧИМ, НИЙТЛЭГ ХЭМ ХЭМЖЭЭ, ШААРДЛАГА

~~6 дугаар зүйл.Төрийн албан хаагчийн эрхэмлэх үнэт зүйлс~~

~~6.1.Төрийн албан хаагч нь дараах үнэт зүйлсийг эрхэмлэн дээдлэнэ:~~

~~6.1.1.Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхол;~~
~~6.1.2.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар баталгаажуулсан хууль дээдлэх ёс;~~

~~6.1.3.хүний эрх, эрх чөлөө, нэр төр, алдар хүнд;~~
~~6.1.4.Монголын төрт ёс, түүх, соёлын уламжлал;~~
~~6.1.5.төрөө дээдлэх ард түмний итгэл.~~

**6 дугаар зүйл.Төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим**

6.1.Төрийн албан хаагч нь Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасан зарчмаас гадна дараах ёс зүйн зарчмыг баримтална:

6.1.1.хүнлэг, энэрэнгүй байх;
6.1.2.үнэнч, шударга байх;
6.1.3.хариуцлагатай байх;
6.1.4.манлайлах;

**6.1.5.хамтач байх.**

**7 дугаар зүйл.Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээ**

7.1.Төрийн албан хаагч ~~нь~~ үйл ажиллагаандаа доор дурдсан ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахин мөрдөнө:

7.1.1.ард түмэндээ чин сэтгэлээсээ үйлчилж, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэх;

7.1.2.зан харилцаа, үг, үйлдлээрээ хүний эрх, эрх чөлөө, нэр төр, алдар хүнд, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;

7.1.3.хууль ёс, шударга ёсыг дээдлэн сахих, ~~хувийн~~ ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;

7.1.4.албан үүргээ гүйцэтгэхдээ гаргасан өөрийн буруутай үйлдэл, эс ~~үйлдлийн~~ үйлдэхүйн төлөө ёс зүйн хариуцлага хүлээдэг байх;

7.1.5.төрийн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн хувьд төвийг сахиж, аливаа улс төрийн эвсэл, хөдөлгөөн, намын нөлөөллөөс ангид байх;

~~7.1.6.төрийн албаны захирах, захирагдах ёсыг биелүүлэхдээ энэ хуулиар тогтоосон зан харилцааны нийтлэг шаардлагыг мөрдөх;~~

7.1.7.төрийн албан хаагчийн хувьд хуулиар тогтоосон иргэний эрх, эрх чөлөөний хязгаарлалтыг хүлээн зөвшөөрөх;

**7.1.8.албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад аливаа хэлбэрээр дарамт үзүүлэхгүй байх, ялгаварлан гадуурхахгүй байх;**

**7.1.9.байгууллагын соёл, дэг журам, албан харилцааны ёс зүйг чанд сахих, улсын болон байгууллагын нэр хүндэд харшилсан аливаа үйлдэл гаргахгүй байх, олон нийтэд үлгэр жишээ, манлайлал үзүүлэх;**

**7.1.10.албан үүргээ гүйцэтгэхдээ нийтийн ашиг сонирхол болон хүрээлэн байгаа орчинд үзүүлэх нөлөөллийг харгалзан үзэх;**

**7.1.11.багаар ажиллах, суралцах, шинэ санаачилгыг дэмжих, хамт олны итгэлцлийг эрхэмлэх, удирдах албан тушаалтны итгэлийг дааж ажиллах.**

**7.2.Төрийн албаны тухай хуулийн 10.1.1, 10.1.3-т заасан албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагч, Авлигын эсрэг хуулийн 4.1.4, 4.1.7, 4.1.9-д**

**заасан этгээдийн ёс зүйн хэм хэмжээг энэ хуульд нийцүүлэн холбогдох хууль тогтоомжоор тогтооно.**

**7.3.Төрийн албаны тухай хуулийн 10.1.2, 10.1.4-т заасан албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагч, Авлигын эсрэг хуулийн 4.1.3, 4.1.5-д заасан этгээдийн ёс зүйн хэм хэмжээг энэ хуульд нийцүүлэн Засгийн газар тогтооно.**

**~~8 дугаар зүйл.Төрийн албан хаагчид тавигдах ёс зүйн нийтлэг шаардлага~~**

~~8.1.Төрийн албан хаагч үйл ажиллагаандаа доор дурдсан ёс зүйн нийтлэг шаардлагыг сахин мөрдөнө:~~

~~8.1.1. энэ хуулийн 7.1.1-д заасан ёс зүйн хэм хэмжээний хүрээнд:~~

~~8.1.1.а.төрт ёс, түүх, соёлын өв уламжлалаас суралцах, Монголын ард түмний соёл, зан үйлийг хүндэтгэх;~~

~~8.1.1.б.төрийн албаны үйл ажиллагаанд итгэл алдах, хардахад хүргэх аливаа үйлдэл, эс үйлдлээс зайлсхийх;~~

~~8.1.1.в.албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ иргэд, үйлчлүүлэгчтэй хүндэтгэлтэй, адил тэгш, эелдэг, хүлээцтэй харилцаж, төрийн үйлчилгээг чирэгдэл, ялгаварлалгүйгээр хөнгөн шуурхай хүргэх;~~

~~8.1.1.г.төрийн байгууллагын үйл ажиллагааны соёл, дэг журмыг чанд сахих;~~

~~8.1.1.д.гадаад улсад ажиллах хугацаандаа Монгол Улсын нэр хүндэд харшилсан аливаа үйлдэл гаргахгүй байх;~~

~~8.1.1.е.албан үүргээ гүйцэтгэж байхдаа согтууруулах ундаа хэрэглэх, байгууллагын дотоод журам болон холбогдох бусад журамд нийцэхгүй байдлаар хувцаслах.~~

~~8.1.2.энэ хуулийн 7.1.2-т заасан ёс зүйн хэм хэмжээний хүрээнд:~~

~~8.1.2.а.төрийн үйлчилгээ үзүүлэхдээ хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, эрүүл мэндийн байдал, бэлгийн хандлагаар нь ялгаварлан гадуурхахгүй байх;~~

~~8.1.2.б.албан үүргээ гүйцэтгэхдээ бусдын нэр төр, алдар хүндийг гутаан доромжлохыг цээрлэх;~~

~~8.1.2.в.албан тушаалын бүрэн эрхээ ашиглан бусдыг дарамтлах, эрхшээлдээ байлгах, хавчин гадуурхахгүй байх;~~

~~8.1.2.г.жендэрийн ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамт үзүүлэхээс ангид байх.~~

~~8.1.3. энэ хуулийн 7.1.3-т заасан ёс зүйн хэм хэмжээний хүрээнд:~~

~~8.1.3.а.өргөсөн тангарагтаа үнэнч байж, эх орон, ард түмнийхээ эрх ашгийг хувийн ашиг сонирхлоос ямагт дээгүүр тавьж, өөрт олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй аливаа нөхцөл байдлаас татгалзах;~~

~~8.1.3.б.хууль зөрчсөн, авлига авсан, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан аливаа үйлдэлтэй эвлэршгүй байж, болзошгүй зөрчлийн талаар урьдчилан сануулах, засуулах арга хэмжээ авах;~~

~~8.1.3.в.албан тушаал, албаны эрх мэдлээ хувийн болон нийгмийн тодорхой бүлэг, байгууллагын явцуу ашиг сонирхлын төлөө ашиглахгүй байх, хувийн зорилгоор албаны нэр ашиглахыг цээрлэх;~~

8.1.3.г.албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглахгүй байх.

~~8.1.4. энэ хуулийн 7.1.4-т заасан ёс зүйн хэм хэмжээний хүрээнд:~~

~~8.1.4.а.өөрийн буруутай үйлдэл, эс үйлдэлдээ дүгнэлт хийж, ёс зүйн хариуцлага хүлээх чадвартай байх.~~

~~8.1.5.энэ хуулийн 7.1.5-д заасан ёс зүйн хэм хэмжээний хүрээнд:~~

~~8.1.5.а.төрийн алба хаах хугацаанд улс төрийн эвсэл, хөдөлгөөн, нам, улс төрийн намын дэргэдэх төрийн бус байгууллагын өмнө үүрэг хүлээх, нөлөөлөлд орж болзошгүй аливаа үйлдлээс татгалзах.~~

~~8.1.6. энэ хуулийн 7.1.6-д заасан ёс зүйн хэм хэмжээний хүрээнд:~~

~~8.1.6.а.удирдах албан тушаалтан нь албан хаагчдын өмнө нэр хүнд, ажил хэргийн үлгэр жишээг үзүүлэх, хамт олны дотор ажил хэрэгч сэтгэл зүйн уур амьсгалыг бүрдүүлэх, ёс зүйн зөрчлийг тухай бүр хянан шийдвэрлэх арга хэмжээ авах;~~

~~8.1.6.б.удирдлагадаа байгаа албан хаагчийг айлган сүрдүүлэх, доромжлох, хясан боогдуулах, ялгаварлан гадуурхах, бэлгийн дарамт үзүүлэх зэргээр албаны хэвийн харилцааг алдагдуулах, хууль бус үүрэг даалгавар өгөхгүй байх;~~

~~8.1.6.в.албан харилцаанд хүний эрх, эрх чөлөө, халдашгүй байдал, хувийн болон гэр бүлийн нууц, нэр төр, алдар хүндийг эрхэмлэх зарчим баримтлах;~~

~~8.1.6.г.албаны үүргээ гүйцэтгэхэд нь бусдад саад учруулах, хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх, албаны харилцааны хэвийн уур амьсгалыг алдагдуулахгүй байх.~~

~~8.1.7.энэ хуулийн 7.1.7-д заасан ёс зүйн хэм хэмжээний хүрээнд:~~

~~8.1.7.а.төрийн албан хаагчийн хувьд хуулиар тогтоосон иргэний эрх, эрх чөлөөний хязгаарлалтыг эсэргүүцэх, үг, үйлдэл, зан байдлаараа илэрхийлэх, бусдыг өдөөн турхирахгүй байх.~~

**8 дугаар зүйл.Төрийн албан хаагчид тавигдах ёс зүйн нийтлэг шаардлага**

**8.1.Төрийн албан хаагч үйл ажиллагаандаа энэ хуулийн 7.1-д заасан ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахин биелүүлэхийн тулд Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйл, Авлигын эсрэг хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 10 дугаар зүйлд заасан үүргээс гадна дараах нийтлэг үүргийг хүлээнэ:**

**8.1.1.иргэний хүсэлтэд анхааралтай хандаж, хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд хариу өгөх;**

**8.1.2.эрх бүхий байгууллагаас баталсан хувцаслалтын шаардлагыг баримтлах;**

**8.1.3.бусдын бие эрхтний онцлогийг зохисгүй үг, үйлдлээр илэрхийлэхийг цээрлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний өөрийгөө илэрхийлэх үйлдлийг даган дуурайхгүй байх, ёс бус үг, хэллэг хэрэглэхгүй байх;**

**8.1.4.бусдын ажил хэргийн санаа бодлыг үл хүндэтгэх, мушгин гуйвуулахгүй байх, худал мэдээллийг аливаа хэлбэрээр тараахгүй байх;**

**8.1.5.бусдын өөрийгөө хөгжүүлэх, мэдлэг ур чадвараа дээшлүүлэх, сурч боловсрох эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хясан боогдуулахгүй байх;**

**8.1.6.албан томилолтоор гадаад улсад ажиллахдаа дипломат ёс, жаягийг чанд баримтлах, Монгол Улсын нэр хүндэд харшилсан аливаа үйлдэл гаргахгүй байх;**

**8.1.7.албаны нэрийг хувийн зорилгоор ашиглахгүй байх.**

**8.2.Төрийн албан хаагчид энэ хуулийн 7.1-д заасан нийтлэг хэм хэмжээг сахин биелүүлэхийн тулд Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйл, Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн Гуравдугаар бүлэгт заасан хориглолт, хязгаарлалтаас гадна дараах үйл ажиллагааг хориглоно:**

8.2.1.төрийн албан хаагчийн хувьд хуулиар тогтоосон иргэний эрх, эрх чөлөөний хязгаарлалтыг үг, үйлдлээр эсэргүүцэх, бусдыг өдөөн турхирах;

8.2.2.удирдлагадаа байгаа төрийн жинхэнэ албан хаагчийг улс төрийн үйл ажиллагаанд татан оролцуулах, оролцох санал тавих;

8.2.3.хүний эмзэг болон хувийн мэдээллийг бусдад дамжуулах, гутаах;

8.2.4.албаны чиг үүрэгтэй холбоотой мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, удирдлагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд саад учруулах;

8.2.5.үндэсний өв уламжлал, ёс заншлыг гутаах, доромжлох үйлдэл хийх;

8.2.6.соёлын ялгаатай хэв шинжийг харьцуулах, шүүмжлэх, ялгавартай хандах;

8.2.7.албаны чиг үүрэгтэйгээ холбоогүй хууль зөрчсөн амлалт өгөх;

8.2.8.албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ
## ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 9 дүгээр зүйл.Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа

9.1.Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүрээнд энэ хуулийн 10.1.д заасан эрх бүхий этгээд, албан тушаалтан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

9.1.1.төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, зөрчлийг арилгах арга хэмжээг авах;

9.1.2.төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, шийдвэрлэлтийн талаар олон нийтэд тогтмол мэдээлэх;

9.1.3.урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг үе шаттайгаар явуулах;

9.1.4.төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, албан тушаалд дэвшүүлэх, шагнал, урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэхдээ ёс зүйн хариуцлага хүлээсэн эсэхийг харгалзах;

9.1.5.иргэд, байгууллага, олон нийтийг мэдээллээр хангах, арга зүйн зөвлөгөө өгөх.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
## ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН АСУУДАЛ ЭРХЛЭХ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД, БҮРЭН ЭРХ

~~9 дүгээр зүйл.Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудал эрхлэх эрх бүхий этгээд~~

~~9.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, ёс зүйн байдалд хяналт тавих, чиг үүргийг Ёс зүйн хороо, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн зөвлөл, төрийн байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтан хэрэгжүүлнэ.~~

~~9.2.Ёс зүйн хороо, Ёс зүйн зөвлөлийн энэ хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа хараат бус байна.~~

**10 дугаар зүйл.Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудал эрхлэх эрх бүхий этгээд**

**10.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиг үүргийг Ёс зүйн хороо, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороо, томилох эрх бүхий албан тушаалтан хэрэгжүүлнэ.**

**10.2.Засгийн газар нь эрхлэх асуудлын хүрээний холбогдох байгууллагын удирдах албан тушаалтны ёс зүйн асуудлын талаар Ёс зүйн дэд хорооны чиг үүргийг хэрэгжүүлнэ.**

**10.3.Ёс зүйн хороо /цаашид “Хороо” гэх/, Ёс зүйн дэд хороо /цаашид “Дэд хороо” гэх / нь бие даасан, хараат бус зарчмаар ажиллана.**

**10.4.Хороо, Дэд хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Хороо хуралдааны дэгээ өөрөө тогтоож болно.**

**10.5.Хороо, Дэд хорооны шийдвэр дүгнэлт хэлбэртэй байна. Шийдвэрт хуралдааныг даргалагч, оролцсон гишүүд, нарийн бичгийн дарга гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.**

## ~~10 дугаар зүйл. Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаарх Ёс зүйн хороо, түүний бүрэн эрх~~

~~10.1.Төрийн албан хаагчийн ёс зүйг сахин мөрдүүлэх, нэгдсэн арга зүйн удирдлагаар хангах, энэ хуулиар харьяалуулсан ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий Ёс зүйн хороог Төрийн албаны зөвлөлийн дэргэд байгуулж ажиллуулна.~~

~~10.2.Ёс зүйн хорооны бүрэлдэхүүн, түүнд тавигдах шаардлага, томилох, ажиллах журмыг Улсын Их Хурал батална.~~

~~10.3.Ёс зүйн хороо төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар дараах бүрэн эрхтэй:~~

~~10.3.1.төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг бууруулах чиглэлээр нэгдсэн бодлого боловсруулах, хууль, эрх зүйн орчныг сайжруулах асуудлаар эрх бүхий байгууллагад санал оруулах;~~

~~10.3.2.төрийн албан хаагчийн ёс зүйг сахиулах мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах;~~

~~10.3.3.Ёс зүйн зөвлөлийн ажиллах журмыг батлах;~~

~~10.3.4.ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, энэ чиглэлээр төрийн байгууллагуудад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;~~

~~10.3.5.энэ хуулиар тусгайлан харьяалуулсан төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шалгаж, дүгнэлт гаргах;~~

~~10.3.6.энэ хуулийн 14.1.6-д заасан дүгнэлтийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх;~~

~~10.3.7.томилох эрх бүхий этгээдээс зөрчил гаргасан албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн эсэхэд хяналт тавих;~~

~~10.3.8.төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн мэдээллийн нэгдсэн сан хөтлөх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх;~~

~~10.3.9.албан үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай гэж үзвэл төрийн холбогдох байгууллагаас мэдээ, мэдээлэл, материал гаргаж өгөх, бусад дэмжлэг үзүүлэхийг шаардах;~~

~~10.3.10.хуульд заасан бусад.~~

**11 дүгээр зүйл.Ёс зүйн хороо, түүний бүрэн эрх**

**11.1.Хороо нь Төрийн албаны төв байгууллагын дэргэд ажиллах бөгөөд ёс зүйн асуудал хариуцсан нэгжтэй байна.**

**11.2.Хорооны үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.**

**11.3.Хороо нь Төрийн албаны зөвлөлийн гишүүд, орон тооны бус 4, нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байна.**

**11.4.Энэ хуулийн 11.3-т заасан орон тооны бус 4 гишүүнийг Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо томилж, чөлөөлнө.**

**11.5.Хорооны үйл ажиллагааны дүрэм, орон тооны бус гишүүнд тавигдах шаардлагыг Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо батална.**

**11.6.Хороо нь төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар дараах бүрэн эрхтэй:**

**11.6.1.төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг бууруулах чиглэлээр бодлого боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавих;**

**11.6.2.хуульд өөрөөр заагаагүй бол Дэд хороо, томилох эрх бүхий албан тушаалтанд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулахтай холбогдсон ~~зөвлөгөө~~ зөвлөмж өгөх, арга зүйн удирдлагаар хангах;**

**11.6.3.төрийн албаны мэргэшүүлэх багц сургалтын агуулга, хөтөлбөрийн хүрээнд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, зохион байгуулах;**

**11.6.4.энэ хуулиар харьяалуулсан төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шалгаж, дүгнэлт гаргах;**

**11.6.5.энэ хуулийн 15.1.5-д заасан дүгнэлтийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх;**

**11.6.6.томилох эрх бүхий ~~этгээдээс~~ албан тушаалтнаас ёс зүйн зөрчил гаргасан албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн эсэхэд хяналт тавих;**

**11.6.7.Дэд хорооны ажиллах журмыг батлах;**

**11.6.8.төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, ~~түүнд~~ тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журмыг баталж, мөрдүүлэх;**

**11.6.9.бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт бусад баримт бичгийг холбогдох байгууллага, аж ахуй нэгж, албан тушаалтнаас гаргуулан авах;**

**11.6.10.төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг зөрчсөн талаарх нэгдсэн дүн, төлөв байдлын талаарх тайлан гаргах;**

**11.6.11.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.**

**11.7.Энэ хуулийн 7.2, 7.3-т заасан ёс зүйн хэм хэмжээг тогтоосон хууль тогтоомж, дүрмийн төсөлд Хорооны саналыг авна.**

**11.8.Хорооны гишүүн хууль тогтоомжийг чанд сахих, хөндлөнгийн нөлөөнд үл автан албан үүргээ шударгаар гүйцэтгэх, төр, байгууллага, аж ахуй нэгж, иргэний хууль ёсны ашиг сонирхол, нэр төрийг хүндэтгэх, өөртэйгөө болон эхнэр, нөхөр, гэр бүл, садан төрлийн бусад гишүүнтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхээс татгалзах үүрэгтэй.**

**~~11 дүгээр зүйл.Төрийн байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтны эрх хэмжээ~~**

~~11.1.Төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтан төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:~~

~~11.1.1.төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сахин мөрдөх орчин нөхцөлийг бүрдүүлэх;~~

~~11.1.2.хариуцсан салбар, байгууллага, нэгжид ажиллаж байгаа төрийн албан хаагчийн ёс зүйн байдалд хяналт тавих;~~

~~11.1.3.хариуцсан салбар, байгууллага, нэгж дотроо гарч байгаа болон үүсч болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөл, эрсдлийг тооцож, зөрчлийг бууруулах зохион байгуулалтын арга хэмжээ авах, жилийн ажлын төлөвлөгөөнд тусгах;~~

~~11.1.4.байгууллагын албан хаагчийн ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шалгаж дүгнэлт гаргах үүрэг бүхий Ёс зүйн зөвлөлийг байгуулах;~~

~~11.1.5.Ёс зүйн хороо, Ёс зүйн зөвлөлийн ёс зүйн зөрчилтэй холбоотой асуудлыг хянан шалгах ажиллагаанд шаардлагатай баримт мэдээллийг гаргаж өгөх;~~

~~11.1.6.ёс зүйн зөрчил үйлдсэн албан хаагчид зөрчлийн шинж байдалд нийцүүлэн энэ хуульд заасан ёс зүйн хариуцлага хүлээлгэх;~~

~~11.1.7.төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээ авах;~~

~~11.1.8.Ёс зүйн зөвлөлийн дүгнэлт, холбогдох албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийг Ёс зүйн хороонд тухай бүр хүргүүлэх;~~

~~11.1.9.томилох эрх бүхий албан тушаалтан, байгууллага өөрийн эрх хэмжээний хүрээнд Ёс зүйн хороо, Ёс зүйн зөвлөлийн дүгнэлтийн дагуу зохих арга хэмжээ авч, хариу мэдэгдэх;~~

~~11.1.10.хуульд заасан бусад.~~

~~11.2.Эрх бүхий албан тушаалтан төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийг санаатайгаар нуун дарагдуулсан бол ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн гэж үзнэ.~~

~~11.3.Албан тушаалтан Ёс зүйн хороо болон Ёс зүйн зөвлөлд дүгнэлт гаргуулахаар, эсхүл дүгнэлт гаргах үйл ажиллагаанд зааварчлах, чиглэл өгөх зэргээр хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.~~

~~11.4.Энэ хуулийн 11.3-т заасныг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.~~

**12 дугаар зүйл.Томилох эрх бүхий албан тушаалтны бүрэн эрх**

**12.1.Томилох эрх бүхий албан тушаалтан төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар дараах бүрэн эрхтэй**:

**12.1.1.төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;**

**12.1.2.хариуцсан салбар, байгууллага, нэгж дотроо гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөл, эрсдэлийг тооцох, зөрчлийг бууруулах зохион байгуулалтын арга хэмжээ авах;**

**12.1.3.Дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх;**

**12.1.4.ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардлагатай тайлбар, баримтыг Хороо, Дэд хороонд гаргаж өгөх;**

**12.1.5.Дэд хорооны дүгнэлтэд үндэслэж, зөрчил гаргасан этгээдэд зөрчлийн шинж байдалд нийцүүлэн хуульд өөрөөр заагаагүй бол ёс зүйн хариуцлага хүлээлгэх;**

**12.1.6.ёс зүйн хариуцлага хүлээсэн этгээдийн шийдвэрийн бүртгэлийг хөтөлж, Хороонд тайлагнах;**

**12.1.7.Дэд хорооны гишүүдийг чадавхжуулах ажлыг зохион байгуулах;**

**12.1.8.хуульд заасан бусад бүрэн эрх.**

~~**12 дугаар зүйл.Ёс зүйн зөвлөл**~~

~~12.1.Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэд төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаарх гомдол, мэдээллийг хянан шалгах, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ёс зүйн зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ ажиллана.~~

~~12.2.Байгууллагын албан хаагчийн тооноос хамааран Зөвлөл нь 3-7 гишүүнтэй байх бөгөөд гишүүд дотроосоо Зөвлөлийн даргыг санал болгон томилуулна.~~

~~12.3.Байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтан нийт албан хаагчдын олонхын дэмжлэг авсан хүнийг Зөвлөлийн гишүүнээр гурван жилийн хугацаагаар томилно.~~

~~12.4.Зөвлөл энэ хуулийн 14.1.6-д заасан дүгнэлтийг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ.~~

~~12.5.Тухайн байгууллагын төрийн албан хаагчийн тоо 25 хүрэхгүй бол Зөвлөл байгуулахгүй. Энэ тохиолдолд төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг тухайн байгууллагын хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж,~~

~~албан тушаалтан хүлээн авч, хянан шалгах бөгөөд дүгнэлт гаргаж, томилох эрх бүхий албан тушаалтанд танилцуулна.~~

13 дугаар зүйл.Ёс зүйн дэд хорооны бүрэн эрх

13.1.Дэд хороо нь байгууллагын албан хаагчийн тооноос хамааран 3-7 гишүүнтэй байх бөгөөд гишүүд дотроосоо даргаа сонгоно.

13.2.Нийт албан хаагчдын олонхын дэмжлэг авсан хүнийг Дэд хорооны гишүүнээр таван жилийн хугацаагаар сонгоно.

13.3.Дэд хороо төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар дараах бүрэн эрхтэй:

13.3.1.энэ хуулиар харьяалуулсан төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шалгаж, дүгнэлт гаргах;

13.3.2.энэ хуулийн 15.1.5-д заасан дүгнэлтийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх;

13.3.3.харьяа байгууллага, бүтцийн нэгжид ёс зүйн асуудлаар ~~зөвлөмж~~ зөвөлгөө өгөх;

13.3.4.хариуцсан салбар, байгууллага, нэгж дотроо гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан, нөхцөл, эрсдэлийг тооцох, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг төлөвлөн зохион байгуулах;

13.3.5.төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, ажлын тайлан, мэдээг гаргаж Хороонд хүргүүлэх;

13.3.6.бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт бусад баримт бичгийг холбогдох байгууллага, аж ахуй нэгж, албан тушаалтнаас гаргуулан авах;

13.3.7.хуульд заасан бусад бүрэн эрх.

13.4.Дэд хорооны гишүүн дараах баталгаагаар хангуулна:

13.4.1.гишүүнээр ажилласны төлөө урамшуулал авах;
13.4.2.хуралдааны үед үүрэгт ажлаас түр чөлөөлөгдөх;
13.4.3.шийдвэрийн улмаас бусдын дарамт, шахалтад өртөхөөс хамгаалуулах.

## ~~ДӨРӨВДҮГЭЭР~~ ТАВДУГААР БҮЛЭГ

## ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ ГАРГАХ, ТҮҮНИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ

### ~~13 дугаар зүйл.Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гомдол, мэдээлэл гаргах~~

~~13.1.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаар иргэн, хуулийн этгээд гомдол, төрийн байгууллага, ажилтан мэдээллийг энэ хуулийн 13.3-т заасан харьяаллын дагуу Ёс зүйн хороонд, эсхүл Зөвлөлд гаргаж болно.~~

~~13.2.Гомдол, мэдээлэлд албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан нөхцөл байдлын талаар тодорхой дурдаж, өөрт байгаа бол нотлох баримтыг хавсаргасан байх бөгөөд Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд[8] заасан шаардлагыг хангасан байна.~~

~~13.3.Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээллийг хуульд заасан эрх бүхий этгээд дараах харьяаллын дагуу шалгаж, шийдвэрлэнэ:~~

~~13.3.1.Зөвлөл өөрийн байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтны томилсон албан хаагчийн болон харьялах доод шатны байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн асуудлыг;~~

~~13.3.2.Ёс зүйн хороо нь энэ хуулийн 13.3.1, 15.4-т зааснаас бусад хуульд заасан үндэслэл, журмын дагуу томилогддог төрийн захиргааны болон төрийн тусгай албаны удирдах албан тушаалтан болон энэ хуулийн 13.5-д заасан улс төрийн албан тушаалтны ёс зүйн асуудлыг.~~

~~13.4.Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Их Хурлын дарга, дэд дарга, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүгч, прокурор, Шүүхийн сахилгын хорооны дарга, гишүүн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, гишүүн, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгчийн ёс зүйтэй холбоотой гомдол гаргах, түүнийг хянан шийдвэрлэх харилцааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.~~

~~13.5.Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, дэд сайд, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх, Улсын Их Хурлын даргын зөвлөх, Ерөнхий сайдын~~

---

[8] Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1995 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

зөвлөх, аймаг, нийслэлийн Засаг дарга, бусад төрийн улс төрийн албан тушаалтны ёс зүйтэй холбоотой гомдлыг Ёс зүйн хороо харьялан шийдвэрлэнэ.

13.6.Ёс зүйн хорооны гишүүний ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг төрийн албан хаагчийн ёс зүйн асуудал хариуцсан Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо хянан үзэж, шаардлагатай тохиолдолд санал, дүгнэлтээ Улсын Их Хуралд танилцуулна.

13.7.Энэ хуулийн 13.3.2-т заасан төрийн албан тушаалтны жагсаалтыг Засгийн газар батална.

**14 дүгээр зүйл.Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гомдол, мэдээлэл гаргах**

**14.1.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаар гомдол, мэдээллийг энэ хуулийн 14.3-т заасан харьяаллын дагуу Хороонд, эсхүл Дэд хороонд гаргана.**

**14.2.Гомдол, мэдээлэлд төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан нөхцөл байдлын талаар тодорхой дурдаж, өөрт байгаа бол нотлох баримтыг хавсаргасан байх бөгөөд Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд[9] заасан шаардлагыг хангасан байна.**

**14.3.Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээллийг дараах харьяаллын дагуу шалгаж, шийдвэрлэнэ:**

**14.3.1.Дэд хороо нь өөрийн байгууллагын албан хаагчийн болон харьялах доод шатны байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтны;**

**14.3.2.Засгийн газар нь аймаг, нийслэлийн Засаг даргаас бусад бүх шатны Засаг дарга, эрхлэх асуудлын хүрээний холбогдох байгууллагын удирдах албан тушаалтан болон Авлигын эсрэг хуулийн 4.1.3, 4.1.5, 4.1.9-д заасан этгээдийн;**

**14.3.3.Хороо нь төрийн өндөр, түүнтэй адилтгах албан тушаалтан болон энэ хуулийн 14.3.1, 14.3.2-т заасанаас бусад төрийн байгууллагын удирдах албан тушаалтан, Авлигын эсрэг хуулийн 4.1.4-т заасан этгээдийн.**

[9] Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1995 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

**14.4.Хорооны гишүүний ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хянан үзэж, шаардлагатай тохиолдолд санал, дүгнэлтээ Улсын Их Хуралд танилцуулна.**

~~**14 дүгээр зүйл.Гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэх**~~

~~14.1.Энэ хуулийн 13.3.1, 13.3.2-т заасан эрх бүхий этгээд гомдол, мэдээллийг хүлээн авч, хянан шалгах ажиллагааг дараах журмаар гүйцэтгэнэ:~~

~~14.1.1.гомдол, мэдээлэл хүлээн авснаас хойш ажлын 3-5 өдрийн дотор, хүндэтгэн үзэх шалтгаантай бол эрх бүхий албан тушаалтны тогтоосон хугацаанд зөрчилд холбогдсон албан хаагчаас бичгээр, эсхүл цахим шуудангаар тайлбар авах, шаардлагатай бол тухайн албан хаагчийг дуудан ирүүлж, тодруулга мэдээлэл авах;~~

~~14.1.2.шаардлагатай тохиолдолд гомдол, мэдээлэл гаргагчаас нэмэлт тайлбар, тодруулга, түүнчлэн эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас мэдээ, баримтыг гаргуулан авах;~~

~~14.1.3.шаардлагатай тохиолдолд шинжээчийн дүгнэлт гаргуулах;~~
~~14.1.4.гаргасан зөрчлийн шинж байдал, учруулсан хохирлын хэмжээг тогтоох;~~

~~14.1.5.цугларсан мэдээ, баримтад дүн шинжилгээ хийх;~~
~~14.1.6.төрийн албан хаагч ёс зүйн зөрчил үйлдсэн эсэхийг тогтоон, дүгнэлт гаргах, түүнд үндэслэлийг тусгах.~~

~~14.2.Дүгнэлтийг дараах этгээдэд баталгаат шуудангаар явуулснаас хойш нийслэлд ажлын 5 өдөр, орон нутагт ажлын 10 өдөр өнгөрсний дараа, эсхүл биечлэн гардуулснаар тэдэнд мэдэгдсэнд тооцно:~~

~~14.2.1.гомдол, мэдээлэл гаргасан этгээд;~~
~~14.2.2.зөрчилд холбогдсон төрийн албан хаагч;~~
~~14.2.3.томилсон эрх бүхий албан тушаалтан, байгууллага.~~

~~14.4.Хуульд заасан эрх бүхий этгээд гомдол, мэдээллийг хүлээн авснаас хойш 30 хоногт багтаан шийдвэрлэх ба нэмэлт шалгалт хийх шаардлагатай бол Ёс зүйн Хорооны болон Зөвлөлийн дарга 30 хүртэл хоногоор нэг удаа сунгаж болно.~~

~~14.5.Ёс зүйн зөрчлийг хянан шалгах ажиллагааны явцад тухайн асуудал нь гэмт хэргийн, зөрчлийн, түүнчлэн сахилгын шинжтэй зөрчил бол гомдол, мэдээллийг холбогдох материалын хамт зохих байгууллага, эрх бүхий албан тушаалтанд шилжүүлнэ.~~

14.6.Иргэний гомдол гаргахтай холбоотой энэ хуулиар зохицуулаагүй бусад харилцааг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу зохицуулна.

14.7.Энэ хуулийн 12.5-д заасан нэгж, албан тушаалтанд төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээлэл гаргах, түүнийг хянан шийдвэрлэх, дүгнэлт гаргах, ёс зүйн хариуцлага хүлээлгэхэд энэ хуульд заасан журмыг мөрдөнө.

14.8.Зөвлөлийн дүгнэлтийг эс зөвшөөрвөл иргэн, хуулийн этгээд, зөрчилд холбогдсон албан хаагч түүнд мэдэгдсэнээс хойш 14 хоногийн дотор харьяалах дээд шатны байгууллагын Зөвлөлд, ийм байгууллагагүй бол Ёс зүйн Хороонд гомдол гаргаж болно.

14.9.Энэ хуулийн 14.8-д заасан эрх бүхий этгээд гомдлыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хянан үзэж дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

14.9.1.дүгнэлтийг хэвээр үлдээх;
14.9.2.дүгнэлтийг хүчингүй болгох;
14.9.3.гомдлыг дахин хянуулахаар буцаах.

14.10.Энэ хуулийн 12.5-д заасан нэгж, албан тушаалтны гаргасан дүгнэлтийг иргэн, хуулийн этгээд, зөрчилд холбогдсон албан хаагч эс зөвшөөрвөл гомдлоо харьяалах дээд шатны байгууллагын Зөвлөлд, эсхүл томилох эрх бүхий албан тушаалтанд гаргана.

**15 дугаар зүйл.Гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэх**

**15.1.Энэ хуулийн 14.3-т заасан эрх бүхий этгээд гомдол, мэдээллийг хүлээн авч, хянан шалгах ажиллагааг дараах журмаар гүйцэтгэнэ:**

**15.1.1.гомдол, мэдээлэл хүлээн авснаас хойш ажлын 3-5 өдрийн дотор, хүндэтгэн үзэх шалтгаантай бол эрх бүхий албан тушаалтны тогтоосон хугацаанд зөрчилд холбогдсон албан хаагчаас бичгээр, эсхүл цахим шуудангаар тайлбар авах, шаардлагатай тохиолдолд тухайн албан хаагчийг дуудан ирүүлж, тодруулга мэдээлэл авах;**

**15.1.2.шаардлагатай тохиолдолд гомдол, мэдээлэл гаргагчаас нэмэлт тайлбар, тодруулга, түүнчлэн эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас мэдээ, баримтыг гаргуулан авах;**

**15.1.3.шаардлагатай тохиолдолд шинжээчийн дүгнэлт гаргуулах;**
**15.1.4.цугларсан мэдээ, баримтад дүн шинжилгээ хийх;**
**15.1.5.төрийн албан хаагч ёс зүйн зөрчил үйлдсэн эсэхийг тогтоон, дүгнэлт гаргах, үндэслэлийг тусгах.**

15.2.Дүгнэлтийг ~~дараах этгээдэд~~ баталгаат шуудангаар явуулснаас хойш нийслэлд ажлын ~~5~~ таван өдөр, орон нутагт ажлын 10 өдөр өнгөрсний дараа, эсхүл биечлэн гардуулснаар дараах этгээдэд мэдэгдсэнд тооцно:

15.2.1.гомдол, мэдээлэл гаргасан этгээд;
15.2.2.зөрчилд холбогдсон төрийн албан хаагч;
15.2.3.томилох эрх бүхий албан тушаалтан, байгууллага.

15.3.Ёс зүйн зөрчлийг хянан шалгах ажиллагааны явцад тухайн асуудал нь гэмт хэргийн, зөрчлийн, сахилгын шинжтэй бол гомдол, мэдээллийг холбогдох материалын хамт зохих байгууллага, эрх бүхий албан тушаалтанд шилжүүлнэ.

15.4.Гомдол, мэдээллийг хүлээн авснаас хойш 30 хоногт багтаан шийдвэрлэх бөгөөд нэмэлт шалгалт хийх шаардлагатай бол 14 хүртэл хоногоор нэг удаа сунгаж болно.

15.5.Иргэний гомдол, мэдээлэл гаргахтай холбоотой энэ хуулиар зохицуулаагүй бусад харилцааг Захиргааны ерөнхий хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу зохицуулна.

15.6.Дүгнэлтийг эс зөвшөөрвөл гомдол, мэдээлэл гаргасан этгээд, түүнд мэдэгдсэнээс хойш 14 хоногийн дотор харьяалах дээд шатны байгууллагын Дэд хороо, Хороонд гомдол гаргаж болно.

15.7.Энэ хуулийн 15.6-д заасан эрх бүхий этгээд гомдлыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хянан үзэж, дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

15.7.1.дүгнэлтийг хэвээр үлдээх;
15.7.2.дүгнэлтийг хүчингүй болгох.

## ~~ТАВДУГААР~~ ЗУРГАДУГААР БҮЛЭГ
## ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД ЁС ЗҮЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ

~~**15 дугаар зүйл.Төрийн албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэх**~~

~~15.1.Хуульд өөрөөр заагаагүй бол томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан төрийн албан хаагчид зөрчлийн шинж байдалд нийцүүлэн дараах ёс зүйн хариуцлагын аль нэгийг ногдуулна:~~

~~15.1.1.хамт олноос, гомдол гаргагчаас, эсхүл олон нийтийн өмнө уучлалт гуйхыг үүрэг болгох;~~

~~15.1.2.өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр сануулах;~~

~~15.1.3.нийт ажилтанд зарлах хэлбэрээр нээлттэй сануулах;~~

~~15.1.4.төрийн албанаас халахыг сануулах;~~

~~15.1.5.төрийн албанаас халахыг сануулах шийтгэл ногдуулсны дараа ёс зүйн зөрчил гаргасан, эсхүл албан тушаалын чиг үүрэгт харшлах ноцтой зөрчил гаргасан бол төрийн албанаас халах.~~

~~15.2.Сонгогддог болон хуульд заасны дагуу томилогддог, бүрэн эрх нь дуусгавар болдог албан тушаалтныг ёс зүйн зөрчилтэй нь холбогдуулан огцруулах, эгүүлэн татах асуудлыг холбогдох хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.~~

~~15.3.Зөвлөлийн дүгнэлт нь үндэслэлгүй болох нь тогтоогдсон бол холбогдох Зөвлөлийн гишүүнд Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэх, эсхүл ажлын үр дүнг үнэлэхэд харгалзан үзэх үзүүлэлт болно.~~

~~15.4.Энэ хуулийн 14.8-д заасны дагуу гомдол гаргасан бол түүнийг эцэслэн шийдвэрлэсний дараа томилох эрх бүхий этгээд ёс зүйн хариуцлага хүлээлгэх асуудлыг шийдвэрлэнэ.~~

~~15.5.Төрийн албан хаагчид энэ хуульд заасны дагуу ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн нь хуульд заасны дагуу эрүүгийн, зөрчлийн, сахилгын хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.~~

~~15.6.Ёс зүйн зөрчлийг илрүүлснээс хойш 6 сар, зөрчил гаргаснаас хойш 12 сараас илүү хугацаа өнгөрсөн бол ёс зүйн хариуцлага хүлээлгэхгүй.~~

~~15.7.Төрийн албан хаагч ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн өдрөөс хойш нэг жилийн дотор ёс зүйн зөрчил гаргаагүй бол түүнийг ёс зүйн шийтгэлгүйд тооцно.~~

**16 дугаар зүйл.Төрийн албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэх**

**16.1.Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 8.1, 8.2-т заасныг зөрчсөн тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан Хорооны, Дэд хорооны дүгнэлтийг үндэслэн зөрчлийн шинж байдал, анх буюу давтан үйлдсэнийг нь харгалзан дараах ёс зүйн хариуцлагын аль нэгийг ногдуулна:**

**16.1.1.гомдол гаргагчид, эсхүл олон нийтийн өмнө уучлалт гуйхыг үүрэг болгох;**

**16.1.2.өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр сануулах;**

**16.1.3.байгууллагын албан хаагчдын өмнө нээлттэй сануулах;**

**16.1.4.төрийн албанаас халах.**

16.2.Төрийн өндөр, түүнтэй адилтгах албан тушаалтныг ёс зүйн зөрчилтэй нь холбогдуулан огцруулах, эгүүлэн татах асуудлыг холбогдох хуульд зааснаы дагуу шийдвэрлэнэ.

16.3.Энэ хуулийн 8.1, 8.2-т заасан Төрийн албаны тухай хуулийн 37, 39 дүгээр зүйл, Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйл, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 10 дугаар зүйл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн Гуравдугаар бүлэгт заасныг зөрчсөн бол тухайн хуульд заасан хариуцлага хүлээнэ.

16.4.Төрийн албан хаагчид энэ хуульд заасны дагуу ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн нь хуульд заасны дагуу эрүүгийн, зөрчлийн, сахилгын хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

16.5.Ёс зүйн зөрчлийг илрүүлснээс хойш 6 сар, зөрчил гаргаснаас хойш 12 сараас илүү хугацаа өнгөрсөн бол ёс зүйн хариуцлага хүлээлгэхгүй.

16.6.Төрийн албан хаагч ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн өдрөөс хойш нэг жилийн дотор ёс зүйн зөрчил гаргаагүй бол түүнийг ёс зүйн шийтгэлгүйд тооцно.

16 дугаар зүйл.Төрийн албан хаагч ёс зүйн хариуцлагыг сайн дураар хүлээх

16.1.Ёс зүйн хорооны болон Зөвлөлийн дүгнэлтээр тухайн албан хаагч нь ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдсон бол түүнд албан ёсоор мэдэгдсэнээр хариуцлагыг сайн дураараа хүлээх боломж олгоно.

16.2.Төрийн албан хаагч дараах хэлбэрээр ёс зүйн хариуцлагыг сайн дураараа хүлээж болно:

16.2.1.хамт олноос, гомдол, мэдээлэл гаргагчаас, эсхүл олон нийтийн өмнө уучлалт гуйх;

16.2.2.ёс зүйн хэм хэмжээг зөрчсөнөө хүлээн зөвшөөрч, өөрийн хүсэлтээрээ албан тушаалаас чөлөөлөгдөх.

16.3.Эрх бүхий албан тушаалтан сайн дураар уучлалт гуйсан төрийн албан хаагчид зөрчлийн шинж байдалд нийцүүлэн энэ хуульд заасан ёс зүйн бусад хариуцлага хүлээлгэж болно.

17дугаар зүйл.Төрийн албан хаагч ёс зүйн хариуцлагыг

**сайн дураараа хүлээх**

**17.1.Хороо, Дэд хорооны дүгнэлтээр тухайн албан хаагч нь ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдсон бол түүнд албан ёсоор мэдэгдсэнээр хариуцлагыг сайн дураараа хүлээх боломж олгоно.**

**17.2.Төрийн албан хаагч дараах хэлбэрээр ёс зүйн хариуцлагыг сайн дураараа хүлээж болно:**

**17.2.1.хамт олноос, гомдол, мэдээлэл гаргагчаас, эсхүл олон нийтийн өмнө уучлалт гуйх;**

**17.2.2.ёс зүйн хэм хэмжээг зөрчсөнөө хүлээн зөвшөөрч, өөрийн хүсэлтээрээ албан тушаалаас чөлөөлөгдөх.**

**18.17 дугаар зүйл.Гомдол гаргах**

18.17.1.Төрийн албан хаагч нь ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо уг шийдвэрийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор шүүхэд гаргаж болно.

## ~~ЗУРГА~~ДОЛДУГААР БҮЛЭГ
## БУСАД ЗҮЙЛ

~~**18 дугаар зүйл.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаар тайлагнах, олон нийтэд мэдээлэх**~~

~~18.1.Хуульд өөрөөр заагаагүй бол томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан төрийн албан хаагчид хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийг холбогдох мэдээллийн хамт улирал бүр, жилийн үйл ажиллагааны тайланг Ёс зүйн Хороонд дараа оны 1 дүгээр сард багтаан хүргүүлэх бөгөөд тайланг өөрийн байгууллагын цахим хуудсанд байршуулна.~~

~~18.2.Ёс зүйн Хороо үйл ажиллагааныхаа тайланг хуульд заасан хугацаанд Улсын Их Хуралд хүргүүлнэ.~~

~~18.3.Ёс зүйн Хороо холбогдох байгууллагаас ирүүлсэн жилийн тайланг нэгтгэж, өөрийн байгууллагын цахим хуудсанд нээлттэй байршуулна.~~

~~18.5.Иргэн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульдзаасны дагуу эрх бүхий албан тушаалтан, байгууллагаас төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэсэн, хариуцлага хүлээлгэсэн мэдээллийн талаар лавлагаа авах эрхтэй.~~

**19 дугээр зүйл.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаар тайлагнах, олон нийтэд мэдээлэх**

**19.1.Хуульд өөрөөр заагаагүй бол томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан төрийн албан хаагчид хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийг холбогдох мэдээллийн хамт улирал бүр, үйл ажиллагааны тайланг дараа оны 1 дүгээр сард багтаан Хороонд хүргүүлэх бөгөөд тайланг өөрийн байгууллагын цахим хуудсанд байршуулна.**

**19.2.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдоогүй бол энэ талаарх мэдээллийг нийтэд мэдээлнэ.**

**19.3.Хороо үйл ажиллагааныхаа тайланг хуульд заасан хугацаанд Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороонд хүргүүлнэ.**

**19.4.Хороо холбогдох байгууллагаас ирүүлсэн жилийн тайланг нэгтгэж, өөрийн байгууллагын цахим хуудсанд нээлттэй байршуулна.**

**20.19 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

20.19.1.Энэ хуулийг 2023 оны ... дугаар сарын ... -ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт:

Төсөл

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2023 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

**ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

~~**1 дүгээр зүйл.**Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 48.11 дэх хэсэг нэмсүгэй:~~

~~"48.11.Энэ хуулийн 37, 39 дүгээр зүйлд заасан зөрчлийг хянан шийдвэрлэх явцад ёс зүйн зөрчил болохыг тогтоосон бол түүнд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан ёс зүйн хариуцлага хүлээлгэнэ."~~

**~~2~~1 дүгээр зүйл.**Төрийн албаны тухай хуулийн III хэсгийн гарчгийн "ЁС ЗҮЙН" гэснийг хассугай.

**~~3~~2 дугаар зүйл.**Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7, ~~37.1.12~~ дахь заалтыг, Аравдугаар бүлэг, 66 дугаар зүйлийн 66.1.1 дэх заалт, 74 дүгээр зүйлийн 74.1.2 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**4~~3~~ дугаар зүйл.**Энэ хуулийг Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт:

Төсөл

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2023 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

**НИЙТИЙН АЛБАНД НИЙТИЙН БОЛОН ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫГ ЗОХИЦУУЛАХ, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Төрийн албаны тухай хууль[2],” гэсний дараа “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль,” гэж нэмсүгэй.

~~**2 дугаар зүйл.**Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийн “Ёс зүйн дэд хороо” гэснийг “Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо” гэж өөрчилсүгэй.~~

**~~3~~2 дугаар зүйл.**Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.1 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**~~4~~3 дугаар зүйл.**Энэ хуулийг Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт:

Төсөл

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"24.4.2.Төрийн албаны зөвлөлийн дэргэдэх Ёс зүйн хорооны асуудал;"

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт:

Төсөл

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2023 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 112.2.15 дахь заалт нэмсүгэй:

"112.2.15.төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн нэгдсэн дүн, төлөв байдлын талаарх Ёс зүйн хорооны тайланг Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороонд жил бүр."

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт:

Төсөл

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

**Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээ авахыг Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Төрийн албаны зөвлөл /Б.Баатарзориг/-д даалгасугай:

1/Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд нийцүүлэн ёс зүйн харилцааг зохицуулж байгаа хууль, тогтоомжид өөрчлөлт оруулах ~~саналаа~~ төслөө боловсруулан Улсын Их Хурлын ~~2022~~ 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

2/Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан журам, ~~жагсаалтыг болон~~ бусад хуульд заасан эрх хэмжээний хүрээнд батлан мөрдүүлж байгаа төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг энэ хуульд нийцүүлэн баталж, мөрдүүлэх арга хэмжээг авах;

3/төрийн албан хаагчийн Ёс зүйн ~~зөвлөлийг~~ дэд хороог байгуулах ажлыг мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар хангаж, үйл ажиллагааг жигдрүүлэх.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо /Б.Баттөмөр/-нд даалгасугай.

Гарын үсэг